



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР**

306 дугаар байр, Чандмань гудамж 3,
Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101

Утас: (976) 70442114, 70442088

Цахим шуудан: ghbhbgbazar@gmail.com

Цахим хаяг: www.bayankhongor.gov.mn

2023.05.05. № 234.
танай 2023.02.17 -ны № 1/80. -т

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Тус газраас 2022 оны жилийн эцсийн
санхүүгийн тайланд өгөгдсөн зөвлөмж, албан
шаардлагын хэрэгжилтийг нотлох баримтын хамт
хүргүүлж байна.

Хавсралт ⁷... хуудастай.

ГАЗРЫН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.ЦЭЦЭНБИЛЭГ



642308387

Баянхонгор аймгийн ГХБХБГазрын 2022 оны
Санхүүгийн тайланд өгөгдсөн зөвлөмж,
албан шаардлагын хэрэгжилт

2023.05.03

№	Өгөгдсөн зөвлөмж	Дүн	Зөвлөмжийн биелэлт
1	2	3	4
1	Ажилласгдсын цалин хөлс түүнтэй адилтгах орлогыг үнэн зөв тодорхойлоогүй. Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1 дэх заалтыг зөрчсөн.	1,500,000	Ажиллагсдын цалин хөлс түүнтэй адилтгах орлогыг үнэн зөв тодорхойлж хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна.
№	Өгөгдсөн албан шаардлага		Албан шаардлагын биелэлт
1	Тус байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй автомашинуудад сэлбэг хэрэгсэл худалдан авч засвар үйлчилгээ хийхдээ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 86 дугаар тогтоолоор батласан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13 дахь заалтыг хэрэгжүүлээгүй.	4,440,000	Хөрөнгөд бүртгэлтэй автомашинуудад сэлбэг хэрэгсэл худалдан авч хийсэн засвар үйлчилгээг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2 дугаар хурлаар хэлэлцүүлж дүгнэлтийг нөхөн гаргуулсан. Мөн 2023 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 86 дугаар тогтоолын дагуу байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.
2	Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 7,5 сая төгрөгийн 1 зарлагын гүйлгээ, нийт 12 иргэн аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан нийт 2.512.0 мянган төгрөгийн үнийн дүн бүхий захиалагчийн техник хяналтын гэрээг байршуулаагүй.		Шилэн дансны 2022 оны цахим хуудасны тухай бүрт оруулах мэдээлэл хэсгийн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ хэсэгт 7.5 сая төгрөгийн 1 ш гүйлгээ, мөн хэсгийн Бонд, зээл, өрийн бичиг баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүссэн аливаа шийдвэр хэсэгт нийт 12 ш захиалагчийн хяналтын гэрээг нөхөн байршуулсан.
	Дүн	5,940,000	

ГАЗРЫН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

НЯГТЛАН БОДОГЧ



А.ЦЭЦЭНБИЛЭГ

Т.МӨНХЗУЛ



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ГАЗРЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 03.

Номгон

ХЭЛЭЛЦСЭН нь:

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын өмч хамгаалах зөвлөл 2023 оны 05 дүгээр сарын 04-ны өдрийн 16:15 минутад газрын даргын өрөөнд хуралдав.

Хуралд: Газрын удирдлагын хэлтсийн дарга А.Цэцэнбилэг, Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга С.Хүрэлхуяг, Ерөнхий нягтлан бодогч Т.Мөнхзул, мэргэжилтэн Л.Батбаяр Жолооч Г.Лхадагва нарын бүрэлдэхүүнтэй хуралдав. Барилгын хэлтсийн дарга С.Хүрэлхуяг хөдөө томилолтоор явж байгаа. Албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтан Г.Даваасүрэн хүүхдээ хараад эмнэлэгт хэвтэж байгаа тул хуралд оролцоогүй.

Хэлэлцэх асуудал:

Өнгөрсөн 2022 онд Ланд-200, Ланд-76, Приус-20 автомашинуудад авсан сэлбэг хэрэгсэлд өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлтийг нөхөн гаргуулах тухай.

СОНССОН нь:

Т.Мөнхзул: Өнгөрсөн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн аудитын газраас “Өмч хамгаалах зөвлөлийн нийтлэг журам”-ын 3.13 дахь “Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжийн их засвар хийх тохиолдолд батлагдсан норм норматив, стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт нь баяжилт хийх зэргээр хяналт тавьж ажиллана” гэсэн заалтыг зөрчсөн байна гэж үзэн албан шаардлага ирүүлсэн тул дүгнэлтийг нөхөн гаргахаар хуралдаж байна. Өнгөрсөн онд автомашинуудад хийгдсэн үйлчилгээ байгаа тул би та бүхэнд товчхон танилцуулъя.

Байгууллагын нэр дээр байдаг 3 машиныг жолооч Г.Лхадагва хариуцан газрын хэмжилт, зураглал хийх, хилийн цэс тогтоох, газрын маргаан шийдвэрлэх, барилгын захиалагчийн хяналт хийх зэрэг өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглан, машины бүрэн бүтэн байдлыг хариуцан ажилладаг. Өнгөрсөн 2022 онд 3 удаа нийт 4,440,000 төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авч автомашинаар үйлчилэх зайлшгүй шаардлагатай ажлуудыг тасалдуулалгүй явуулсан. Үүнд:

642202006

ЛАНД-200 машинд

1. Өвлийн дугуй 2 ширхэг
2. Моторын тос масло, редуктор тос
3. Агаар шүүгч, салоны агаарын шүүгч
4. Филтр/ моторын тосны шүүгч
5. Парны тохируулга

ПРИУС 20 машинд

1. 5 бул солих
2. Моторын тос, тосны шүүр солих
3. Агаар шүүгч
4. Наклад
5. Аккумулятори
6. Рулийн аппарат

Ланд-76 машинд

7. Чагтан гол
8. 3-р араа
9. Сальник
10. Туслах хропны таб/ толгой араа эдгээр сэлбэгүүдийг худалдан авсан.

А.Цэцэнбилэг: Эдгээр хэрэгслүүд нь автомашинуудыг ажилд бэлэн байлгахад зайлшгүй шаардлагатай байсан хийх ёстой ажлууд гэж ойлгож байна. Өмнө нь бид нар зөвлөлийг хуралдуулж дүгнэлт гаргадаггүй байсан. 2023 оноос авах шаардлагатай сэлбэг хэрэгслүүдийг өмнөх 1-р хуралдаанаар шийдвэрлээд дүгнэлтээ гаргаад өгчисөн байгаа. Үүнээс хойш зайлшгүй шаардлагатай байгаа сэлбэг хэрэгслүүдээ жолооч тухай бүрд асуудлаа оруулж хэлэлцүүлээд шийдвэр гарсны дараа хөрөнгөө гаргаад шийдүүлээд явдаг зарчимтай болж байна шүү.

Дээрх сэлбэгүүдийн дуусах хугацаа нь болчихсон зайлшгүй солих шаардлагатай сэлбэгүүд байсан гэсэн үг үү?

Г.Лхадагва: Тийм. Сольсон сэлбэгүүдийн эдэлгээ ашиглалт нь дуусч эвдрэн солихоос аргагүй болсон байсан. Жишээ нь Ланд-76-д хийгдсэн сэлбэгүүд гэхэд хангайн сумдаар барилгын техник хяналтаар явж байхад 3-р арааны шүд, чагтан гол хугарч ажиллагаагүй болж ирсэн тэгээд солих шаардлагатай болсон, өнгөрсөн 2 сард нөхөн бүрдүүлэлтийн билүү ажил хүлээлцэж ажлаар билүү Хүрээмарал Баянбулаг сумдаар явж байхад ланд 200-ын дугуй буудсан. Тэгээд зуны дугуйгаа сольж тавьж байгаад 11 сард өвлийн дугуйтай болж сольсон. Приус 20-ын аккумулятор бас байнга суудаг жоохон явж халаагаад дөнгөж унтраагаад удаагүй байхад ахиад суудаг. Тэгээд хүн дуудаж холбож асаадаг болсон байсан бас тэнхлэг тохиргоо алдагдаж рулийн аппаратад дуу орж холхидог болсон гэх мэт зайлшгүй солих шаардлагатай байсан. Хөдөөгүүр их явдаг болохоор дор дор нь янзлуулаад явахгүй бол машинаа улам муутгах аюултай.

Т.Мөнхзул: Ер нь зайлшгүй солих шаардлагатай сэлбэгүүдээс бусад нь жил бүр автомашинуудад хийгддэг үйлчилгээнүүд байсан. Өвөл зуны тос масло, эд

ангиудын тос тосолгоо, агаар шүүгч гэх мэт. Автомашиныудад сэлбэг хэрэгсэл худалдан авах болон үйлчилгээ хийлгэхдээ жолоочоор хүсэлт бичүүлж даргын зөвшөөрлийг авснаар 2022 оны 04, 11, 12 дугаар саруудад сэлбэг хэрэгсэлүүдийн гүйлгээ хийсэн. Яг үйлчилгээ хийлгэсэн тухай бүр автомашин, сэлбэг хэрэгслийн зургийг авч баталгаажуулаад явсан.

Л.Батбаяр: Солигдож бичигдсэн 2 үйлчилгээ байна тэрийг солиорой. Сая 4 сард Ланд-200-д авсан дугуйныхаа зарлагын падан дээр нь машиныхаа гүйлтийг тэмдэглээд аваарай.

А.Цэцэнбилэг: Өмнөх хуралдаанаар яригдсан ланд 200-ын арын шил хагарсан юм байна тэр юунаас болж хагарсан бэ?

Г.Лхадагва: Томилолтоор явж байхад чулуу үсрээд хагарсан.

А.Цэцэнбилэг: Үүнээс хойш хэнтэй ч юм ажил гүйцэтгэж явахад автомашин эвдэрч гэмтсэн бол тэрийг ажлын хэсгийн удирдлагадаа хэлж илтгэх хуудсан дээр заавал оруулж бичүүлж бай. Өмнө нь ерөөсөө бичдэггүй байсан болохоор хэзээ эвдэрч гэмтсэн нь тодорхойгүй болоод байна. Машин тэрэгний бүрэн бүтэн байдал аюулгүй байдал чинь гүйцэтгэж байгаа ажилтай чинь хамт явж байгаа болохоор багаараа явсан, ажил үйлчилгээгээ хийсэн, бүрэн бүтэн, эсвэл эвдэрч гэмтсэн үү, дугуй хагарсан бол дугуй хагарсан шүү гэдгээ илтгэх хуудсан дээрээ зайлшгүй хэлж тэмдэглүүлж байх ёстой шүү.

Г.Лхадагва: За.

Т.Мөнхзул: Мөн томилолтоор явж ирээд машинаа няравтайгаа нүдээр үзэн хүлээлцэж автамашинд эвдрэл гэмтэл гарсан юмуу гараагүй бол энэ явалтаар ямар нэгэн асуудалгүй яваад ирлээ гэдгээ хэлж байгаарай. Хэрэв илтгэх хуудсан дээр автомашинтай холбоотой асуудлыг тэмдэглүүлээгүй байгаад илтгэх хуудас нягтланд ирсэн тохиолдолд няраваас тодруулж эвдрэл гэмтлийг хэлж нөхөн тэмдэглүүлж байх юм шүү.

Г.Лхадагва: За ойлголоо. Бас хагарч буудсан дугуйг хадгалаад хураагаад байлгаад байх уу?

Т.Мөнхзул: Өмч хамгаалах байнгын зөвлөл байгууллагын хөрөнгөтэй холбоотой бүх хөдөлгөөнийг хийж байгаа учраас зөвлөлийн шийдвэргүй хөрөнгийн устгал хийж болохгүй шүү. Хагас бүтэн жилийн тооллогоор тооллогын комисс ажиллаад зөвлөлд ажлаа танилцуулснаар ӨХЗөвлөл нь шийдвэрээ гаргаж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарын шийдвэрээр болон ГХБХБГазрын даргын шийдвэрээр актлаж устгах ёстой шүү.


А.Цэцэнбилэг: За тэгвэл өнгөрсөн онд автомашинуудад авч хийсэн сэлбэг, үйлчилгээнүүд нь зайлшгүй шаардлагатай байсан гэж үзээд зөвлөлийн дүгнэлтийг нөхөн гаргахыг зөвшөөрч байна уу?

Зөвлөлийн гишүүдийн 100%-ийн саналаар зөвшөөрөв.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 2022 онд авсан автомашинуудын сэлбэг хэрэгсэл болон үйлчилгээнүүд нь зайлшгүй солих, хийлгэх шаардлагатай байсан учир Зөвлөлийн гишүүдийн 100%-ийн саналаар худалдан авахаар шийдвэрлэж, хурал 16:35 минутад өндөрлөв.

ХЯНАСАН:
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
НЯГТЛАН БОДОГЧ



А.ЦЭЦЭНБИЛЭГ

Т.МӨНХЗУЛ

ХУРАЛД ОРОЛЦСОН ГИШҮҮД:

Л.БАТБАЯР

Г.ЛХАДАГВА

Шилэн дансны мэдээлэл

	A	B	C	D	E	F
1	Д/д	Шийдвэр гаргагч	Шийдвэрийн огноо	Шийдвэрийн дугаар	Төрөл/хөрөнгө зарцуулах, өр авлага үүсгэх	Шийдвэрийн хуулбар
2	1	ГХБХБГазрын дарга	2022.11.28	A/35	Хөрөнгө гаргах тухай	35.pdf
3	2	ГХБХБГазрын дарга	2022.11.28	A/36	Үнэлгээний баг байгуулах тухай	36.pdf
4	3	ГХБХБГазрын дарга	2022.12.06	A/37	Байгууллагын эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсэг байгуулах тухай	37.pdf
5	4	ГХБХБГазрын дарга	2022.12.09	A/38	Ажлын хэсэг байгуулах тухай	38 (1).pdf
6	5	ГХБХБГазрын дарга	2022.12.13	A/39	Хөрөнгө худалдаж авах тухай	39.pdf
7	6	ГХБХБГазрын дарга	2022.12.15	A/40	Урамшуулал олгох тухай	40 (1).pdf
8		ГХБХБГазрын дарга	2022.12.19	A/42	нэг удаагийн тусламж олгох тухай	42 (1).pdf
9		ГХБХБГазрын дарга	2022.12.19	A/43	Хөрөнгө гаргах тухай	43 (1).pdf
10		ГХБХБГазрын дарга	2022.12.19	A/44	Тусламж олгох тухай	44 (1).pdf
11		ГХБХБГазрын дарга	2022.12.19	A/45	Шагналын мөнгө олгох тухай	45 (1).pdf
12		ГХБХБГазрын дарга	2022.12.19	A/46	Шагнал олгох тухай	46.pdf
13		ГХБХБГазрын дарга	2022.01.01-2022.12.	1-12	Барилгын захиалагчийн хяналтын гэрээ	Барилга гэрээ.pdf

Файл	Мөрийн дугаар		
35.pdf	2	Файлыг татаж авах	Файлыг устгах
36.pdf	3	Файлыг татаж авах	Файлыг устгах
37.pdf	4	Файлыг татаж авах	Файлыг устгах
38 (1).pdf	5	Файлыг татаж авах	Файлыг устгах
39.pdf	6	Файлыг татаж авах	Файлыг устгах
40 (1).pdf	7	Файлыг татаж авах	Файлыг устгах
42 (1).pdf	8	Файлыг татаж авах	Файлыг устгах
43 (1).pdf	9	Файлыг татаж авах	Файлыг устгах
44 (1).pdf	10	Файлыг татаж авах	Файлыг устгах
45 (1).pdf	11	Файлыг татаж авах	Файлыг устгах
46.pdf	12	Файлыг татаж авах	Файлыг устгах
Барилга гэрээ.pdf	13	Файлыг татаж авах	Файлыг устгах

